


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/529

Алтай хот

┌ Хөрөнгө зарцуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 259 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 50 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Шуурхай штабт шаардлагатай тоног төхөөрөмж, бичиг хэрэг, интернетийн зардал 2,178,000 төгрөг, гамшигт өртсөн айл өрхүүдэд тусламж үзүүлэхээр Улаанбаатар хотоос гэр тээвэрлэн ирсэн тээврийн зардал 4,800,000 төгрөг, аймгийн хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хоолны зардал 4,415,200 төгрөг, нийт 11,393,200 (арван нэгэн сая гурван зуун ерэн гурван мянга хоёр зуун) төгрөгийг Гамшгийн сангаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

